



МОНГОЛ УЛСЫН  
ЭРҮҮЛ МЭНДИЙН САЙДЫН ТУШААЛ

2012 оны 06 сарын 08 өдөр

Дугаар 198

Улаанбаатар хот

Г

Г

“Биеийн тамир, спортын тэргүүний  
ажилтан” тэмдгийн загварыг  
шинэчлэн батлах тухай

Монгол Улсын Яамны эрх зүйн байдлын тухай хуулийн 26.3 дахь заалт,  
Засгийн газрын 1997 оны 52, 53 дугаар тогтоолын үндэслэн ТУШААХ нь:

1. Монгол улсын Засгийн газрын шагнал “Биеийн тамир спортын тэргүүний ажилтан” хүндэт тэмдгийн загварыг шинэчлэн баталсугай.
2. Энэ тушаал гарсантай холбогдуулан Эрүүл мэндийн сайдын 2008 оны 18 дугаар тушаалын гуравдугаар хавсралтаар батлагдсан “Биеийн тамир спортын тэргүүний ажилтан” хүндэт тэмдгийн загварыг хүчингүй болсонд тооцсугай.

САЙД

Н.ХҮРЭЛБААТАР



080335

Эрүүл мэндийн сайдын 2012 оны  
198 тоот тушаалын хавсралт

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ШАГНАЛ  
“БИЕИЙН ТАМИР СПОРТЫН ТЭРГҮҮНИЙ АЖИЛТАН”  
ХҮНДЭТ ТЭМДГИЙН ЗАГВАР



“Биеийн тамир спортын тэргүүний ажилтан” тэмдгийн өндөр нь 45 мм, өргөн нь 28 мм-ийн хэмжээтэй /зуйван/ элбис хэлбэртэй байна. Тэмдэг нь төв хэсгээсээ гадагш цацарч буй алтан шаргал, талст цацрагтай байх бөгөөд цацрагийн төв хэсэгт олимп болон спортын галт бамбарыг товоилгон дүрсэлж өгсөн байх ба энэ нь “Монголын биеийн тамир спортын амжилт мөнхөд мандан бадарч цацран гэрэлтэж байх болтугай” гэсэн бэлэгдлийг агуулж байгаа юм.

Тэмдгийн цацрагийн дээд хэсэгт хөх дэвсгэртэй, дугуй алтан шар хүрээний голд төрийн Алтан соёмыг байрлуулж доод талд нь алтан шар туузан дээр монгол бичгээр “Биеийн тамир спортын тэргүүний ажилтан” гэж

хөх өнгөөр бичсэн байна. Тэмдгийн цацрагийн хоёр талаар хүндэтгэлийн лаврын навчийг товоилгон сийлж өгнө. Тэмдэгний ар талд хувцсанд тогтоох сүлбээрэн зүйтэй байна.